



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

3. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

4. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

My Doc:/tushaal/.

1150500125




Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 05 сарын 03 өдрийн
22 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН
НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2013.05.03

Улаанбаатар хот

| д/д | Аж ахуйн нэгжийн нэр | Оноосон нэр | Байршил |
|-----|------------------------|-------------|---|
| 1 | Ээвж номт ХХК | Бамбино | Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Доржийн гудамж, 38 тоот |
| 2 | Хөх тэнгэрийн заяа ХХК | Доллар | Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, 21-р хороолол, үйлдвэрчний эвлэлийн гудамж 75 тоот |
| 3 | Тэрэлж сүйх ХХК | Тэрэлж | Налайх дүүрэг, 6-р хороо, Жо Вангийн адагт |
| 4 | Алтанбумба мандал ХХК | Рич Хилл | Баянгол дүүрэг, 7-р хороо Дилав хутагт Жамсранжавын гудамж |
| 5 | Хөх нуур трейд ХХК | Капелла | Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, 47/8 тоот |



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 05 сарын 03 өдрийн
22 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

2013.05.03

Улаанбаатар хот

| д/д | Аж ахуйн нэгжийн нэр | Оноосон нэр | Байршил |
|-----|----------------------|-------------|--|
| 1 | Иргэн С.Батмөнх | Зээргэнэ | Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 75 |
| 2 | Мөнхийн сарнай ХХК | Сарнай | Баянгол дүүрэг, 3-р хороо Замчдын 8-3 тоот |
| 3 | Иргэн Б.Хандаа | Жунгле | Баянгол дүүрэг, 5-р хороо |
| 4 | Туна ХХК | Дабль юу | Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, 21-р хороолол үйлдвэрчний эвлэлийн гудамж 41 тоот |